

## ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ОБЪЕКТУУДЫН ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

**Товч агуулга:** Энэхүү илтгэлийн зорилго нь Төрийн тусгай хамгаалалттай объектуудын галын аюулгүй байдлын хамгаалагдсан байдал, төрний эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлоход оршино.

**Abstract:** The article attempts to analyze the protection status of the government's specially-protected facilities for improving the control and inspection structure and identify the solutions for the challenges.

**Төвлөх үгс:** төрийн тусгай хамгаалалттай объект, галын аюулгүй байдал

**Key words:** government's specially-protected facilities, fire protection, control and inspection, implementation.

Төр, захиргааны барилгууд нь 1950-1970 онуудад тухайн үеийн норм стандартаар баригдсан бөгөөд гал тэсвэршилтийн зэрэглэл багатай норм норматив, стандартын шаардлага хангаагүй, хийц бүтээцийг нь олон удаа өөрчилсөн байдаг зэрэг нь гал төймрийн эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Гамшиг судлалын хөрөөлэнгийн эрдэмтэдийн судалгаагаар 2004-2018 онд Монгол Улсад тохиолдсон аюулт үзэгдэл, ослын 86%-ийг объектын гал төймэр эзэлж, төрний улмаас 862 хүн амь насаа алдан, 541 хүн бэртэж гэмтсэн үзүүлэлттэй<sup>1</sup> байна. Төрийн 80 орчим хувь нь нийслэлийн Улаанбаатар хотод гарсан байдаг. Төрийн тусгай хамгаалалттай объектод галын зөрчил багагүй гарч байсан. Тухайлбал, 2011, 2015 онд Төрийн ордны хурлын танхим, өргөө тасалгаанд гал гарч нийслэлийн Гал унтраах 10 дугаар ангиас унтрааж байсан байна. Тиймээс Төрийн тусгай хамгаалалттай объектуудын галын аюулаас урьдчилан сэргийлэх хяналтын ажлыг өргөжтэй зохион байгуулах нь нэн чухал асуудал болоод байна.

### ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ОБЪЕКТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН:

Төрийн тусгай хамгаалалттай объектын халдашгүй байдлыг Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулиар хуульчилж өгсөн байна. Тухайлбал,

**Хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт** “Улсын Их Хурлын чуулганы болон Засгийн газар, үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаан, олон улсын дээд хэмжээний уулзалт, хэлэлцээр, хурал, зөвлөлтүүд нь Төрийн тусгай хамгаалалтанд байна” гээд **хуулийн 8 дугаар зүйлд** “Монгол Улсын Төрийн ордон, Ерөнхийлөгчийн ордон, өргөө, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын зориулалтын орон сууц, төрийн харш, гадаадын дээд, үндэр хэмжээний зочдын байрлах зочид буудал, хамгаалуулагчийн хөдөлгөөж яваа болон зориулалтын тээврийн хэрэгсэлийг хуулиар төрийн тусгай хамгаалалтад байна”<sup>2</sup> гээд мөн Төрийн ордны тухай хуульд “Төрийн ордон, төрний инженерийн байгууламж нь газар хөдлөлт, гал, усны аюулаас найдвартай хамгаалагдсан байх<sup>3</sup>.....”, гэсэн нь барилгын аюулгүй байдлын баталгааг зааж өгсөн байна.

1. Гамшиг судлалын хөрөөлөн, 2004-2018 оны статистик мэдээ
2. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 8-р зүйл
3. Төрийн ордны тухай хуулийн 10-р зүйлийн 3 дахь заалт

Мөн БНБД 13-04-03 норм дүрэм “Барилга байгууламжийн инженер шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм”<sup>4</sup>-д

- Модон материалтай барилга 30-60 жил
- Холимог материалтай барилга/модон ба бетон/50-100 жил
- Төмөр бетонон материалтай 100-200 жил
- 200 жилээс дээш гэж насжилтын хугацааг заасан бол Төрийн ордны барилгын блокуудын насжилтыг хялснэгтээр харуулбал,

**Хялснэгт 1. Төрийн ордны барилгын насжилт**

| 1951 барилга | 1961 оны барилга | 1981 оны барилга | 2008 оны барилга |
|--------------|------------------|------------------|------------------|
| 68 жил       | 58 жил           | 38 жил           | 11 жил           |

Төрийн ордны анхны барилга нь 68 жилийн насжилттай эдэлгээний зэрэглэл өндөр ашиглалтын хугацаа дууссан байна. Мөн 1951, 1961 онд ашиглалтанд орсон барилгуудыг буулгаж, шинээр төлөвлөлт хийх нь зүйтэй гэж мэргэжлийн хяналтын байцаагч нарын 2011 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 06/50/618 тоот дүгнэлт гарсан байна.

**ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ОБЪЕКТЫН ГАЛ ТӨЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ӨНӨГИЙН БАЙДАЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА:**

Төрийн ордны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэгт “Төрийн ордон нь галын мэргэжлийн албаны байнгын харуул, хамгаалалт, гал унтраах болон галын дохиоллын техник хэрэгсэлтэй байна” гэсэн нь Төрийн ордны галын аюулгүй байдлыг хангуулах анхны нэгж буюу галын алба анх 1962 онд БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 342 тоот тогтоолоор НАХЯамны Төв гал командын орон тооноос гурван гал снөөгчийг Төрийн ордонд томилон ажиллуулснаар эхэлсэн байдаг.

Одоогоор Төрийн ордны Гамшгаас хамгаалах тасгийн гамшгаас хамгаалах болон гал төймрийн улсын хяналтын байцаагч, гал снөөгч нар Төрийн ордон, Засгийн газрын байрууд, Их тэнгэр цогцолбор зэрэг төрийн тусгай хамгаалалттай объектууд болон гадаадын улс орноос Монгол Улсад хийх албан ёсны Төрийн өндөр дээд хэмжээний айлчлал, Төрийн ёслол хөндөгтийн арга хэмжээ, олон улсын дээд төвшний уулзалт болон Төрийн тусгай хамгаалалттай объектуудын гамшиг, галын аюулгүй байдлыг хангуулах ажилд Төрийн тусгай хамгаалалтын газар бусад байгууллагуудтай тусгайлсан чиг үүрэгтэйгээр хамтран ажиллаж байна.

Онцгой байдлын байгууллагаас Төрийн тусгай хамгаалалтын газартай зочны зам, маршрут, зочид буудал, барилга байгууламж зэрэг объектуудад Монгол Улсын Тамшгаас хамгаалах тухай”, Талын аюулгүй байдлын тухай” хууль, гамшгийн болон гал төймрийн улсын хяналтын дүрэм, стандарт, техникийн нормативын хэрэгжилтийг шалгаж хамтран ажилладаг бөгөөд тухай бүрт илэрсэн зөрчил дутагдалыг газар дээр нь засуулах, цаашид арилгуулахаар улсын хяналтын байцаагчийн эрх зүйн бичиг баримтыг үйлдэж Гал төймрийн улсын хяналтын байцаагчийн эрхийн хүрээнд албан шаардлага, танилцуулга, мэдэгдэл, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг төр зогсоох, дүгнэлт бичих зэргээр биелэлтийг тооцон ажилладаг.

Гал түймрийн улсын хяналтын байцаагч нь Төрийн тусгай хамгаалалтын газар болон Төрийн ордны Хамгаалалтын алба, Төр, засгийн байлчилгээг эрхлэх эрхлэх газар, Засгийн газрын байруудын Нийтлэг байлчилгээний газрын инженер техникийн ажилтан нартай хяналт шалгалтыг дараах дэс дарааллаар явуулдаг байна. Үүнд:

1. Төлөөлөгч болон төлөөлөгчт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалт
2. Шуурхай шалгалт /Төрд тутам дотоод эзлэг/
3. Ажлын байр хөлээж авах биелэлтийн шалгалт /Гал түймрийн эрсдэлтэй ажлын байр өргө тасалгааг ажил дууссаны дараа аюулгүй байдлыг бэрэн хангуулсаны дараа хаалгыг цоожлуулж, лацдуулдаг/
4. Хамтарсан шалгалт /Орой 20.30, шөнийн цагаар 00-01 цагуудад хамгаалалтын алба, Төр, засгийн байлчилгээг эрхлэх газрын инженер, техникийн ажилтан нар Төрийн ордны бэхлэвэр тасалгаанд аюулгүй байдлын эзлэг шалгалт хийдэг/
5. Нарийн эзлэг шалгалт /Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, УИХ-ын чуулган, Засгийн газрын хуралдаан, Төрийн Ёслол хөндөтгэлийн танхим, Их тэнгэр, Маршал харш зэрэг объектод улирал бүр, зочны айлчлал бусад арга хэмжээний өд тухай бүр нь зам маршрутын эзлэг хийдэг/ зэрэг чиглэлээр явуулж байна.

Дээрх шалгалтын хэрээнд 2016-2018 он буюу сүүлийн 3 жилийн хугацаанд хяналт шалгалт хийсэн тоо эзлэлтийг график, хэснэгтээр харуулбал.

## Хүснэгт 2. Гал түймрийн улсын хяналт шалгалтын судалгаа

| №              | Шалгалтын төрөл          |                       |                                   |                                    |                                         |                                |                          | Албан бичиг                         |         |          |             |                                                   | Сургалт |                |
|----------------|--------------------------|-----------------------|-----------------------------------|------------------------------------|-----------------------------------------|--------------------------------|--------------------------|-------------------------------------|---------|----------|-------------|---------------------------------------------------|---------|----------------|
| Он             | Шалгасан<br>объектын тоо | Шуурхай үзлэг шалгалт | Ажлын байр хүлээж авах<br>биелэлт | Хамтарсан үзлэг<br>/шөнийн цагаар/ | Нарийн үзлэг /Зочин,<br>албан тасалгаа/ | Нийт илрүүлсэн зөрчлийн<br>тоо | Арилгуулсан зөрчлийн тоо | Заавал биелүүлэх албан<br>шаардлага | Дүгнэлт | Мэдэгдэл | Танилцуулга | Торгууль ноогдуулсан<br>мөнгөн дүн<br>/төгрөгөөр/ | Сургалт | Хамрагдсан хүн |
| 2016           | 155                      | 2190                  | 8474                              | 365                                | 77                                      | 1058                           | 298                      | 34                                  | 3       | 112      | 12          | 720000                                            | 137     | 4541           |
| 2017           | 128                      | 1963                  | 7288                              | 730                                | 48                                      | 870                            | 217                      | 28                                  | –       | 75       | 21          | 270000                                            | 81      | 2061           |
| 2018           | 117                      | 2494                  | 7539                              | 730                                | 25                                      | 892                            | 316                      | 38                                  | 3       | 71       | 6           | 1100000                                           | 62      | 1976           |
| Бүгд           | 400                      | 6647                  | 23301                             | 1825                               | 150                                     | 2820                           | 831                      | 100                                 | 6       | 258      | 39          | 2190000                                           | 280     | 8578           |
| Жилд<br>дундаж | 134                      | 2215                  | 7767                              | 608                                | 50                                      | 940                            | 277                      | 33                                  | 2       | 86       | 13          | 1290000                                           | 93      | 2859           |

**Зураг 1.Төрийн тусгай хамгаалалттай объектуудад хяналт шалгалт хийсэн судалгаа**



Дээрхи графикаас харахад хяналт шалгалтаар явахад илрүүлсэн зөрчлийн тоо 2016 онд 1058, 2017 онд 870, 2018 онд 892 болж өссөн үзүүлэлттэй байна. Харин арилгуулсан зөрчлийн тоо 2016 онд 298, 2017 онд 217, 2018 онд 316 болсон байна. Судалгаанаас харахад жилийн дундаж илэрсэн зөрчлийн тоо 940, арилгуулсан зөрчлийн тоо 277, бэрэн гүйцэт арилаагүй 663 зөрчил байна.

**Зураг 2. Төрийн тусгай хамгаалалттай объектуудад эрх зүйн баримт бичиг өгсөн судалгаа**



Дээрх судалгаанаас харахад бэрэн гүйцэт арилахгүй байгаа зөрчлөлийг товчхон дурдвал:

1. “Барилга байгууламжийн галын дохиоллын систем БНБД 21-04-05” норм дүрмийн 12 дахь заалтын дагуу объектод галын дохиоллын систем огт төлөвлөгдсөнийг.
2. “Усан хангамж гадна сэлжээ ба байгууламж БНБД 40-02-16” норм дүрмийн дагуу барилгын гадна шугамд гал унтраах автомашиныг усаар тасралтгүй хангах усны эхлэсвэр буюу галын гидрант огт төлөвлөгдсөнийг, төлөвлөгдсөн гидранд огт ажиллагаа байхгүй.
3. Барилга доторхи усан хангамж, ариутгах татуурга БНБД 40-05-16-ын 5 дугаар бөлийн шаардлагын дагуу усан хангамж төлөвлөгдсөнийг, усан хангамжийн даралт муу, нөц насос тавигдаагүй, гал унтраах даралтын хоолой, хушуу дутуу, чанар муудсан.
4. Цахилгааны байгууламжийн дүрэм/БД 43-101-03/-ын 6.1, 6.2 дахь заалт цахилгаан ашиглалт, угсралт норм дүрэм зөрчигдөж, хуучны барилгын цахилгаан хангамж, тэжээл муудсан кабель утасны ашиглалтын хугацаа дууссан, чанар муутай уртасгагч ашигладаг.
5. “Хийн хангамж” БНБД 42-01-04-ийн 9.37 заалт. Бөлэг баллонт төхөөрөмжийг ндсэн барилгын гадна талд байрлуулах шаардлагыг зөрчсөн мөн цахилгаан тоног төхөөрөмжийн байдал нь тэсрэлтээс хамгаалах аюулгүй байдлыг хангаж чадаагүй. хоосон баллон зориулалтын бус газар хадгалдаг. Гал тогооны өрөөнд шингэрүүлсэн шатах хийн бөлэг баллонт төхөөрөмжийг цахилгаан тоног төхөөрөмжөдтэй өрөөнд байрлуулсан.
6. Барилга байгууламжийн галын аюулгүй байдал БНБД 21-01-02 норм дүрмийн 6.22 дахь заалтыг зөрчиж, барилгын авралтын гарц болон нөц гарцыг ослын гэрлээр тоноглоогүй.
7. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.9 дэхь заалт Талтөймрийн аюулын нэлгээг энэ хуулийн 18.5, 18.6, 18.7, 18.8-д заасны дагуу эрсдэлийн нэлгээ хийгдээгүй зэрэг гэх мэтийн олон зөрчлөлд бэрэн гүйцэт арилж өгөхгүй байсаар байна.

Учир нь Төр, захиргааны барилгууд нь хамгийн сүүлдээ 1950-1970 онуудад баригдсан бөгөөд газар хөдлөлтийн тэсвэржилт байхгүй, тухайн өөийн норм, стандартыг мөрдөж баригдсан бөгөөд сүүлийн өөийн галын аюулгүй байдлын норм стандартын шаардлагыг бэрэн хангахгүй байна. Мөн эдийн засаг, төсөв мөнгөтэй холбож тайлбарласаар удаж байна.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь заалт “Төрийн болон нутгийн захиргааны байгууллага тухайн жилийн төсвийн 1.0 хувийг, хуулийн этгээд тухайн жилийн өйлдвэрлэл, өйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд төлөвлөж зарцуулна” гэж заасан нь биелэлээ олохгүй байна.

## ДҮГНЭЛТ

Төрийн тусгай хамгаалалттай объектуудын галын аюулгүй байдал, хамгаалагдсан байдлыг хангахад тулгамдаж байгаа асуудлуудыг судалж эзлээ. Судалгаанаас харахад барилга байгууламжийн ихэнх нь 1950-1970 оны үед баригдсан нь газар хөдлөлтийн тэсвэржилт байхгүй, галын аюулгүй байдлын норм нормативын баримт бичиг, стандартын хэрэгжилтийг бүрэн хангаж чадахгүй байна. Төрийн ордны анхны барилга нь 68 жилийн насжилттай эдэлгээний зэрэглэл өндөр ашиглалтын хугацаа дууссан байна. Мөн 1951, 1961 онд ашиглалтанд орсон барилгуудыг буулгаж, шинээр төлөвлөлт хийх нь зүйтэй гэж мэргэжлийн хяналтын байцаагч нарын 2011 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 06/50/618 тоот дүгнэлт гарсан нь эрсдэлтэй объектын тоонд орж байгаа нь Төрийн ордны тухай хуулийн 10-р зүйлийн 3 дахь хэсэгт “Төрийн ордон, төмний инженерийн байгууламж нь газар хөдлөлт, гал, усны аюулаас найдвартай хамгаалагдсан байх.....” гэсэн хуулийн заалт бүрэн зөрчигдөж байна.

Төр, захиргааны байгууллага нь байгууллагын гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг хангахад жил бүрийн төсөвт Гамшгаас хамгаалах тухай хуулинд заасан Төрийн болон нутгийн захиргааны байгууллага тухайн жилийн төсвийн 1.0 хувийг, хуулийн этгээд тухайн жилийн өйлдвэрлэл, өйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд төлөвлөж зарцуулна<sup>5</sup> гэж заасан нь биелэлээ олохгүй байгаа нь гамшгийн эрсдэл буурахгүй цаашид гамгийн эрсдэлийн магадлал өндөр байгаа нь харагдаж байна.

Онцгой байдлын байгууллагаас Төрийн тусгай хамгаалалтын газартай зочны зам, маршрут, зочид буудал, барилга байгууламж зэрэг объектуудад Монгол Улсын Тамшгаас хамгаалах тухай”, “Галын аюулгүй байдлын тухай” хууль, гамшгийн болон гал төймрийн улсын хяналтын дүрэм, стандарт, техникийн нормативын хэрэгжилтийг шалгаж хамтран ажилладаг бөгөөд тухай бүрт илэрсэн зөрчил дутагдалыг газар дээр нь засуулах, цаашид арилгуулахаар Гал төймрийн улсын хяналтын байцаагчийн эрхийн хүрээнд албан шаардлага, танилцуулга, мэдэгдэл, дүгнэлт бичих зэргээр биелэлтийг тооцон ажилладаг байна. Гэвч төсөв мөнгө шаардсан зөрчлөлд бүрэн арилахгүй байна. Мөн судалгаанаас харахад хяналт шалгалтаар явахад илрүүлсэн зөрчлийн тоо 2016 онд 1058, 2017 онд 870 болж буурч, 2018 онд 892 болж өссөн үзүүлэлттэй байна. Харин арилгуулсан зөрчлийн тоо 2016 онд 298, 2017 онд 217, 2018 онд 316 болсон байна. Судалгаанаас харахад 3 жилийн дундаж илэрсэн зөрчлийн тоо 940, арилгуулсан зөрчлийн тоо 277, бүрэн гүйцэт арилаагүй 663 зөрчил байгаа нь тус объектуудын галын аюулгүй байдал бүрэн хангагдаагүй эрсдэл ихтэй объектуудын тоонд орж байна гэж дүгнэн үзэж болох юм.

## САНАЛ

- Засгийн газрын байруудад орон тооны гал төймрийн улсын хяналтын байцаагч томилж ажиллуулах. 1999 оноос 2007 оны хооронд Төрийн ордны Галын албаны бүрэлдэхүүнд Засгийн газрын байрууд хариуцсан гал төймрийн улсын хяналтын байцаагчтай байсан байна. Энэ нь Төрийн тусгай хамгаалалтын газрын ажилтан нартай хамтран галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг цаг алдахгүй зохион байгуулан үргэлжлүүлэн ажиллаж байсан байна.

- Барилга байгууламжид урсгал засвар, өйлчилгээг хийх, Хий хангамжийн системийг ашиглахад эрх бүхий байгууллагуудаас батлан гаргасан холбогдох стандарт, дүрэм, журам, нормын заалтуудыг мөрдлөг болгох.

- Төрийн тусгай хамгаалалттай барилга, бусад зүйл, тэдгээрийн орчинд эмх замбараагүй байдал үүсэх, гамшиг, гэнэтийн осол гарах зэргээр нөхцөл байдал хүндэрсэн үед цагдаа,

дотоодын цэрэг, онцгой байдал болон бусад мэргэжлийн байгууллагтай хамтран ажиллах төлөвлөгөө, гэрээ, санамж бичиг байгуулах.

- Газар хөдөлтийн тэсвэржилтгүй мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан барилга байгууламжийг нурааж дахин төлөвлөх, газар хөдөлтийн тэсвэржилтийг сайжруулах.

- Барилга байгууламжийн цахилгаан хангамж, угсралтыг иж бүрэн сольж мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, мөн орчин үеийн гал унтраах чадвар сайтай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх.

- Төрийн болон нутгийн захиргааны байгууллага тухайн жилийн төсвийн хувийг, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд төлөвлөж, зарцуулж байх.

### **ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ**

1. Монгол Улсын Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, 1995 он
2. Монгол Улсын Төрийн ордны тухай хууль, 2001 он
3. Монгол Улсын Галын аюулгүй байдлын тухай хууль, 2015 он
4. Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017 он
5. Засгийн газрын тогтоол, №48 Гал төмрийн улсын хяналтын дүрэм., 2016 он
6. Засгийн газрын тогтоол, № 40 Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм., 2018 он
7. Засгийн газрын тогтоол, №65 Жагсаалт батлах тухай., 2012 он
8. Тусгаар тогтнол сэтгүүл, №3 (43). УБ., 2018 он 65 дахь тал
9. Гамшиг судлалын хэрэглэн, 2016-2018 оны статистик мэдээ
10. БНБД 13-04-03 норм дүрэм “Барилга байгууламжийн инженер шугам сэлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм”